



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 167

Мандалговь

“Тод баяарт” ХХК-тай гэрээ байгуулах
эрхийг хүчингүй болгох тухай

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалт, Аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 66 тоот албан бичгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Сумдын албан хэрэгцээнд бохир сорох автомашин”-ыг нийлүүлэхээр шалгарсан “Тод баяарт” ХХК нь цахим тендertээ “Капитрон” банкны Дорноговь аймаг дахь салбарын захирлын зээл олгох тухай тодорхойлолтыг хуурамчаар үйлдэж ирүүлсэн байх тул Аймгийн засаг даргын тамгын газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн 43,660,000 (дөчин гурван сая зургаан зуун жаран мянга) төгрөгөөр гэрээ байгуулах эрх олгох тухай 2/447 тоот албан бичиг, мөн 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/51 дугаартай тушаалыг тус тус хүчингүйд тооцсугай.

2. “Сумдын албан хэрэгцээнд бохир сорох автомашин” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтыг дахин зохион байгуулах тухай хүсэлтийг Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *Л.Доржбат* Л.ДОРЖБАТ

486210090